



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/119

Чойр

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 1 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Шилжин ирсэн иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаатар)-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4212400279

Аймгийн Засаг даргын 2024 оны  
03 дугаар сарын 26-ны өдрийн  
А/119 дугаар захирамжийн хавсралт



## ШИЛЖИН ИРСЭН ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, тэдгээрийн салбарын байгууллагууд /сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёл урлаг/, орон нутгийн өмчит болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, хувийн хэвшлийн байгууллагад нэн шаардлагатай, дутагдалтай байгаа ажлын байранд ажиллахаар, сумдын хөдөөгийн багуудын малчин өрхүүдэд туслах малчнаар ажиллахаар, Улаанбаатар хотоос бизнесээ шилжүүлэн орон нутаг үйл ажиллагаа явуулахаар тус тус шилжин ирсэн иргэн, аж ахуйн нэгжид орон сууц, хашаа байшин, гэр, газар худалдан авах, түрээслэх, хувийн орон сууц, хашаа барих, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх дэд бүтцийн чиглэлээр дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулна.

1.2. Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Газрын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид энэ журам нийцсэн байна.

1.3. Дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахдаа Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын 2022 оны “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 419 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй Говьсүмбэр” хөтөлбөрийг тус тус үндэслэл болгоно.

1.4. Дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ тэгш, шударга, ил тод байх зарчмыг баримтална.

1.5. Орон нутагт дутагдалтай байгаа ажлын байрны судалгаа, жагсаалтыг аймгийн Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хамтран жил бүрийн 1 дүгээр сард багтаан гаргаж олон нийтэд мэдээллэнэ.

### Хоёр. Дэмжлэгийн төрөл хэлбэр

#### 2.1. Иргэнд олгох дэмжлэгт:

2.1.1. Орон сууц, хашаа байшин, гэр, газар худалдан авах;

2.1.2. Орон сууц, хашаа байшин, гэр, газар түрээслэх;

2.1.3. Хувийн орон сууц, хашаа барих;

2.1.4. Худалдаж авсан болон барьсан хашаа, байшингийн дэд бүтцийг шийдвэрлэх;

2.1.5. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу иргэнд өмчлүүлэхээр шийдвэрлэсэн газарт тэргүүн ээлжинд шилжин ирсэн иргэнийг хамруулах бодлогыг баримтлан дэмжлэг үзүүлэх;

2.1.6. Орон сууц худалдан авахад холбогдох хууль тогтоомжийн дагуу ипотекийн зээлийн дэмжлэгийг тэргүүн ээлжинд үзүүлэх ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах.

#### 2.2. Аж ахуйн нэгжид олгох дэмжлэгт:

2.2.1. Үйл ажиллагаа явуулах байр, газрын түрээслэх зардалд;

2.2.2. Үйл ажиллагаа явуулах байр, газар худалдан авах зардалд;

2.2.3.Хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.2.4.Газар эзэмших, ашиглах асуудлыг Газрын тухай хуульд заасны дагуу дэмжлэг үзүүлэх.

#### Гурав. Дэмжлэг олгох шалгуур

##### 3.1.Иргэний хувьд:

3.1.1.Орон нутагт шилжин ирж Улсын бүртгэлийн хэлтэс болон багийн Засаг даргад бүртгэлээ хийлгэсэн байх.

3.1.2.Тухайн жилийн дутагдалтай ажлын байрны жагсаалтад багтсан ажлын байранд 6 сараас дээш хугацаагаар ажилласан байна.

3.1.3.Орон нутагт 3-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах /Ажил олгогчтой гэрээ байгуулна/.

##### 3.2.Бизнес эрхлэгчийн хувьд:

3.2.1.Бизнесийн үйл ажиллагаагаа шилжүүлэн Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэст бүртгүүлсэн байх.

3.2.2.Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг орон нутагт төвлөрүүлдэг байх.

3.2.3.Харьяа сумдын Засаг даргатай “Нийгмийн хариуцлагын гэрээ” байгуулж, хамтран ажиллах.

#### Дөрөв.Хүсэлт гаргахад бүрдүүлэх бичиг баримт, хүлээн авах, бүртгэх, шийдвэр гаргах

4.1.Хүсэлт гаргагч дараах баримт бичгийг бүрдүүлж аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсээр уламжлан аймгийн Засаг даргад ирүүлнэ.

##### 4.1.1.Иргэний хувьд:

4.1.1.1.Хүсэлт

4.1.1.2.Иргэний үнэмлэхний хуулбар /e-mongolia аппаас татаж авсан лавлагаа байж болно/

4.1.1.3.Оршин суугаа хаягийн тодорхойлолт /шилжин ирсэн байх/

4.1.1.4.Мэргэжлийн диплом, мэргэшлийн сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар.

4.1.1.5.Ажил олгогч байгууллагатай ажлын байрны талаар тохиролцсон нөхцөл, хөдөлмөрийн гэрээ, тушаал шийдвэрийн хуулбар.

4.1.1.6.Ажил олгогчийн тодорхойлолт.

##### 4.1.2.Аж ахуйн нэгжийн хувь дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

4.1.2.1.Хүсэлт

4.1.2.2.Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

4.1.2.3.Татварын байгууллагын тодорхойлолт

4.1.2.4.Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт

4.2.Иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг улирал бүрийн эхний сарын 30-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хүлээн авч бүртгэн аймгийн Засаг даргад танилцуулан, мэргэжлийн байгууллагатай хамтран судалж, шийдвэрлүүлэн хэрэгжилтэд хяналт тавина.

#### Тав. Дэмжлэг олгох

5.1.Журмын 4.2-д заасан шийдвэр гарснаар аймгийн Засаг даргын Тамгын газар хүсэлт гаргагчийн дэмжлэгийг дараах байдлаар олгоно.

5.1.1.Орон сууц, хашаа байшин, гэр, газар, ажлын байр худалдан авч байгаа тохиолдолд зээл олгосон эсхүл зээл олгохоор шийдвэрлэсэн банк, төлбөр авагчийн дансанд аймгийн Засаг даргын шийдвэр, холбогдох гэрээг тус тус үндэслэн шилжүүлэх.

5.1.2.Орон сууц, хашаа байшин, гэр, газар, ажлын байр түрээсэлж байгаа тохиолдолд аймгийн Засаг даргын шийдвэр, холбогдох гэрээг үндэслэн түрээслүүлэгчийн дансанд шилжүүлэх.

5.2. Дэмжлэгт хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг нэгтгэн, тайлагнах үйл ажиллагааг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хариуцна.

5.3. Дэмжлэгт хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжид мөнгөн дэмжлэгийг эхний жилд олгох бөгөөд дараагийн жилүүдэд бусад төрлийн дэмжлэгийг хууль журмын хүрээнд олгох эсэх асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлүүлж болно. Үүнд:

а. Газар өмчлөх, эзэмших, ашиглах;

б. Ипотекийн зээлд хамруулах.

в. Бусад

#### Зургаа. Санхүүжилт

6.1. Дэмжлэгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх бөгөөд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгана. Төсвийн төсөлд тусгах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс хариуцан гүйцэтгэнэ.

6.2. Тухайн жилд батлагдсан төсвийн 15 хүртэлх хувийг боловсролын салбарт, 15 хүртэлх хувийг эрүүл мэндийн салбарт, 20 хүртэлх хувийг малчин болон хувийн хэвшлийн байгууллагуудад, 50 хүртэл хувийг бусад төрийн байгууллагад олгохоор хуваарилна.

6.3. Иргэн, аж ахуйн нэгжид олгох мөнгөн дэмжлэгийн дээд хэмжээ гурав хүртэл сая төгрөг байх бөгөөд дэмжлэг хүсэгчид 1 удаа олгоно.

6.4. Санхүүжилтийн хэмжээг тухайн жилийн төсөв санхүүгийн нөхцөл байдалтай уялдуулан жил бүр шинэчлэн тогтоож болно.

6.5. Тухайн жилийн батлагдсан төсөвт багтаагүй тохиолдолд шаардлага хангасан дэмжлэг хүсэгчийн хүсэлтийг дараа жилийн төсөвт тусган шийдвэрлэж болно.

#### Долоо. Бусад

7.1. Дэмжлэгийг хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсан, дэмжлэгийг зориулалтын бусаар зарцуулсан, ажил олгогч этгээдтэй байгуулсан гэрээний хугацаагаа зөрчсөн тохиолдолд дэмжлэгийн мөнгийг буцаан төлүүлнэ. Дэмжлэгийн мөнгийг буцаан төлүүлэх үйл ажиллагааг ажил олгогч байгууллагатай хамтран аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хариуцан төлүүлэх бөгөөд дэмжлэгт хамрагдсан иргэн төлөхөөс татгалзсан тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

7.2. Дэмжлэг олгох үйл ажиллагаатай холбоотой гарсан маргааныг Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

--oOo--